



2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани болох “Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани нь төмөр замын салбарт улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр үүссэн өмчийг эзэмших, ашиглах, бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох, төмөр замын салбарт үндэсний компани болгох зорилгоор 2008 оны гуравдугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 82 дугаар тогтоол, мөн сарын 20-ны өдрийн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр байгуулагдсан.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын төмөр замын үндэсний сүлжээг хөгжүүлэх, төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани байх.



АЛСЫН ХАРАА

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, төмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь шийднэ.



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Төмөр замын салбарт хүртээмжтэй, аюулгүй тээвэр, инновацын шинэчлэл хийх

Зах зээлийн таатай орчин бүрдүүлэх
Засаглал, нийгмийн үр нөлөөг сайжруулах
Эдийн засгийн өсөлтийг хангах

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- Төмөр замын дэд бүтцийг барих эзэмших, ашиглах
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх
- Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмших, ашиглах, үйлдвэрлэх, угсрах, түрээслэх, засварлах

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ОХИН БОЛОН ХАРААТ КОМПАНИУД

- "Тавантолгой төмөр зам" ХХК
- "Монголиан порт групп" ХХК
- "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам" ХХК
- "Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам" ХХК
- "Шивээхүрэн төмөр зам" ХХК

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, ажилтнуудын ажлын гүйцэтгэл, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд компанийн удирдлагын шуурхай хуралдааныг тухай бүр зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газар болон холбогдох эрх бүхий дээд байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хангах талаар газар, албадын дарга нарт үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангаж ажилласан.



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**



1.1.1. Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 36 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрүүдэд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, бүрдүүлэлт нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, компанийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэх, чиг үүрэг орон тоо давхардуулан тооцсон эсэхэд хяналт шалгалт хийж ажилласан бөгөөд шалгалтын үеэр Захиргаа, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой бичиг баримтуудыг хугацаанд нь гарган өгч ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 01/583 дугаар албан бичгээр хяналт шалгалтын дүгнэлт, хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг ирүүлсний дагуу хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01//1685 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

1.1.2. Зам, тээврийн хөгжлийн яам

Зам, тээврийн хөгжлийн сайдын “Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил” болгон зарлах тухай №01, “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Зам, тээврийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай №02, Зам, тээврийн салбарын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай №04, Үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай №05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох мэргэжилтэнд цахимаар тус тус хүргүүлж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох мэргэжилтэнд цахимаар тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.6.1.1, 3.6.1.3, 3.6.3.3-т тусгагдсан арга хэмжээний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг авч үзвэл:

I. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-

Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ.

II. Баруун босоо чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгана.

III. БНХАУ-ын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төвийн төслийг эхлүүлнэ.

1.1.3. Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яамны ХШҮДАГ-т 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/2136 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтыг авч үзвэл:

I. Төмөр замчдыг бэлтгэж ур чадварыг дээшлүүлнэ.

II. Засаглал, нийгмийн үр нөлөөг сайжруулах компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.

III. Эдийн засаг, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулна.

IV. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

V. Төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.

VI. Экспортыг нэмэгдүүлж, ачаа тээвэр-логистикийн үйл ажиллагааг өргөжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.





VII. Авлигын эсрэг хууль тогтоомж, арга хэмжээ хэрэгжүүлнэ. Эдгээр зорилтууд болно.

1.2. Захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа

1.2.1. Хүний нөөцийн чиглэлээр

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, 4 газар, 1 алба, 12 хэлтэс, орон нутагт Цогтцэций өртөө, Төмөртэй өртөө, Төмөр замын зам, барилгын механикжсан анги салбартай, орон тооны дээд хязгаар 550 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/116 дугаар тушаалаар 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/02 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралтаар баталсан “Ажлын байрны тодорхойлолт”-ыг хүчингүй болгож, 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор компанийн нийт ажилтнуудын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын дагуу боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсэг тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

 <p>Төв оффис, өртөө зэрлэгийн нийт ажилтнуудын албан тушаалын тооллогыг 2023 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.</p>	 <p>Тооллогоор 212 албан тушаалын буюу газар, хэлтсийн 16 албан тушаалын тодорхойлолт, нийт давхардсан тоогоор 228 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.</p>	 <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан өмнөх зохион байгуулалтын бүтцээс хасагдсан зарим чиг үүргийг холбогдох нэгжийн албан тушаалд нэгтгэх</p>	 <p>Бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг тодорхойлж, томъёолох зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.</p>
---	---	--	--

Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/117 дугаар тушаалаар “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, холбогдох бусад хууль тогтоомж, ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг судлах, компанийн одоо мөрдөж байгаа бодлогын баримт бичигт зарчмын өөрчлөлт оруулах, тусгах саналыг нэгжүүдээс авч нэгтгэх зэрэг ажлуудыг зохион байгуулж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулсан.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын байранд тавигдах шаардлага, түүнийг мөрдөх түр журам”-д ажилтнуудын цаг ашиглалт, хувцаслалт, ажлын байран дахь эмх цэгц, дэг журам, хариуцлагын талаар нарийвчлан тусгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн “Ажлын байранд тавигдах шаардлага, түүнийг мөрдөх түр журам”-д тусгагдсан зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоол, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалт, “Хөдөлмөрийн дотоод журмын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтыг тус тус үндэслэн Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар “Компанийн засаглалын дотоод журам”-ийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан бөгөөд “Компанийн засаглалын дотоод журам”-ын төслийг боловсруулах шатандаа явж байна.

1.2.2. Тушаал шийдвэр, өргөдөл

ХАБЭА-н сургалт

“Монголын төмөр зам” ТӨХК нь “Монголын ажил олгогч эздийн холбоо”-той хамтран ажил мэргэжлийн стандарт олон улсын туршлага түүний практик хэрэглээ, ХАБЭА-н ажилтны ажил үүргийн хуваарь, функц/матриц, ХАБЭА-н хууль эрх зүйн зохицуулалт ба эрсдэлд суурилсан хандлага, ХАБЭА-н удирдлагын тогтолцоо ба арга хэрэгслүүд зэрэг цогц сэдвийн хүрээнд ХАБЭА-н мэдлэг олгох, дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан.

“Эерэг харилцаа, зөв хандлага” аяны хүрээнд

Байгууллагын хамт олны уур амьсгал, эв нэгдлийг сайжруулах зорилтын хүрээнд Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газраас 11 дүгээр сард “Эерэг харилцаа, зөв хандлага” сарын аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд “Хамт олны харилцаа хувь хүний манлайлал”, “Хувь хүний хөгжил”, “Бидний мэдэх компьютер”, “Төлөвлөлт ба амжилт”, “Эерэг сэтгэлгээ”, “Тээврийн нэгдсэн платформын тухай” сургалтуудыг зохион байгуулсан ба Захиргаа, хүний нөөцийн хэлтсээс нийт ажилтнуудын идэвх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж ажилласан.

“Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт” сургалт

2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 4 газар, 1 албанаас нийт 12 албан хаагчийг Архивын ерөнхий газрын архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын тухай сургалтад хамруулж, Үндэсний архивын сан хөмрөгтэй танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн ЗТХЯ-ны болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинар, зөвлөгөөнд тухай бүр ажилтнуудыг хамруулж байгууллагын оролцоог хангаж ажилласан.

1.2.3. Хүний нөөцийн төлөвлөлт

2024 оны хүний нөөцийг бодлогын төлөвлөлт, хүний нөөцийг хэрхэн сайжруулах, компанийн албан хаагчдыг дэмжих, мэргэшүүлэх, залгамж халааг бэлтгэх, хэрхэн урамшуулах, хэрхэн хариуцлага тооцох асуудлыг хамруулсан цогц төлөвлөгөөг

боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/1998 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Хүний нөөцийн цогц төлөвлөгөөг агуулгаар ангилан авч үзвэл:

1. Хүний нөөцийн бодлогын стратеги төлөвлөгөөний хүрээнд:

- 1.1. Компанийн хүний нөөцтэй холбоотой эрх зүйн орчныг төмөр замын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох,
- 1.2. Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхыг хөгжүүлэх,
- 1.3. Ажилтнуудын чадавхыг хөгжүүлэх, карьер өсгөх стратеги хэрэгжүүлэх,
- 1.4. Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, томилох, дэвшүүлэх, шилжих арга хэлбэрийг хөгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг тооцох, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх тогтолцоог төгөлдөржүүлэх,

2. Байгууллагын хүний нөөцийг сайжруулах ажлын хүрээнд:

- 2.1. Байгууллагын өөрчлөлт, хөгжил, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратеги төлөвлөгөө, хувь хүний мэдлэг, ур чадварыг үндэслэн хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлох,
- 2.2. Сургалтын хэрэгцээг үндэслэн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан жил бүр баталж, хэрэгжүүлэх,
- 2.3. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлж, их, дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төв, холбогдох мэргэжлийн байгууллага болон хамтрагч байгууллагыг түшиглэн зохион байгуулах,
- 2.4. Шинэ ажилтныг чиглүүлэх дасан зохицох хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх,
- 2.5. Хүний нөөцийн сургалт хөгжлийн тогтолцоог байгууллагын өөрчлөлт, хөгжлийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох арга хэмжээг авах,
- 2.6. Хүний нөөцийн мэдээллийн программын сайжруулалтыг хийлгэх,
- 2.7. Газар, нэгжийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжих, сургалтын шинэ арга зүйг ашиглан ажиллах,

1.2.6. Архив, албан хэрэг хөтлөлт

Архивын баримтад нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийгдсэн ба “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн байнга хадгалах удирдлагын 189 нэгж 19,442 хуудас PDF файлыг үүсгэж, цахим мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн. Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/122 дугаар тушаалаар “Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, архивын үйл ажиллагааг явуулж байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд хийгдсэн ажлын баримт бичгийг цэгцлэхэд заавар, зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлж дахин боловсруулалтад хяналт тавьж мэдээ, мэдээллээр хангаж, 3295 хадгаламжийн нэгжийг үүсгэж, Архивын ерөнхий газрын зураг төслийн архивд шилжүүлсэн.

Компанид ирсэн бичгийг цаасан хэлбэрээр, цахим шуудангаар тус тус хүлээн авч байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 2164 албан бичиг ирснийг бичиг хэргийн мэдээллийн санд бүртгэн холбогдох нэгж, ажилтанд компанийн дотоод сүлжээгээр шилжүүлсэн. Мөн 2139 албан бичгийн төслийг газар, нэгжүүдээс хүлээн авч хэвлэмэл хуудсанд стандартын дагуу буулган албажуулж, холбогдох газарт хүргүүлэн ажилласан. Ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг ангилан авч үзвэл:

- Хариуг илгээж хаагдсан 1143
- Танилцаж хаагдсан 979
- Шийдвэрлэх шатанд 42

1.2.10. Захиргааны чиглэлээр зохион байгуулсан бусад ажлууд

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал томилогдсоноос хойш 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн 100 хоногийн ажлын тайланг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн нийт ажилтнуудад тайлагнасан.

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр компанийн нийт албан хаагчид сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн анхны үйлдвэрчний эвлэлийн хороог байгуулж, даргыг сонгосон. 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр “Үйлдвэрчний эвлэлийн хороо”-г хуулийн этгээдийн Улсын бүртгэлд бүртгүүлж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хороо” оноосон нэр, тамга, тэмдгийг авсан. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хороо, Ажил олгогчийн төлөөллийн “Хамтын гэрээ”-ний төслийг боловсруулж байна.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн төв болон “Цогтцэций өртөө”, “Төмөртэй өртөө”-ний хамт олны төлөөллийг хамруулан компанийн 2023 оны үйл ажиллагааг дүгнэн хэлэлцэх, ирэх оны зорилтыг танилцуулах хамт олны хурлыг 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулса

1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 23/18 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 379 дүгээр тогтоолын дагуу Дотоод хяналтын алба, Тээврийн хяналтын газруудыг нэгтгэж Хяналтын алба байгуулагдсан бөгөөд компанийн батлагдсан дүрэм, журмуудын хэрэгжилтэд хяналт тавих, дотоод үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж гаргах, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих, компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

1.6.1. Дотоод аудит

Гүйцэтгэх захирлын 2021 оны А/19 тоот тушаалаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-д зааснаар дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлан ажиллана гэж заасны дагуу аудитын чиглэлээр 2023 оны III, IV дүгээр улиралд Гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг, чиглэл, батлагдсан удирдамжийн дагуу 9 асуудлаар зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг гаргуулан үнэлэлт өгч ажиллаж байна. Үүнд:

I. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийх асуудлаар Төлөвлөлтийн хэлтэст 4 зүйлийн зөвлөмжийг өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелэсэн.

II. БНХАУ-д үйлдвэрлэгдсэн CKD4b серийн MR2301, 2305 дугаартай гол замын зүтгүүрүүдэд дунд засварын ажил хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерт дотоод аудит хийж 6 зүйлийн зөвлөмжийг өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелэсэн.

III. “Плас эстимэйт” ХХК-ийн тээврийн тооцоотой холбоотой асуудлаар аудит хийж дараах 4 зүйлийн зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үүнд:

Хэрэгжилтийн байдал: Тээвэр ложистикийн төлөвлөлтийн газраас дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн талаар доорх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр уулзалт хийж “Плас эстимент ХХК-ийн санхүүгийн төлбөр тооцооны талаар актын төслийг харилцагч компани руу илгээсэн бөгөөд харилцагч компанийн зүгээс хариу ирүүлсэн тохиолдолд гэрээ дүгнэсэн актыг үйлдэнэ.

“Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээврийн үйл ажиллагааны ачаа тээвэрлэлтийн түр тарифыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.

Зөрчил гаргасан ажилтнуудад “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн дагуу сануулах арга хэмжээ авч хурлын тэмдэглэлд тусгаж баталгаажуулан ажиллаж байна.

IV. “Монголын төмөр зам” ТӨХК, “УБТЗ” ХНН-ийн хооронд байгуулж буй “Төр өөрийн өмчийг түрээслүүлэх гэрээ”-ний 6 дугаар хавсралтад түрээсийн үнэлгээний задаргааг гаргахад дансны үнэ болон хавсралт нь өнөөгийн үнэ цэнээр тооцоход хүндрэлтэй асуудал байгаа талаар Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсээс зөвлөмж хүссэний дагуу Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам” болон бусад эрх зүйн баримт бичгийн дагуу тухайн гэрээг байгуулахад анхаарах дараах 4 зүйлийн зөвлөмжийг өгсөн.

Хэрэгжилтийн байдал: Тээвэр ложистикийн төлөвлөлтийн газрын Ачаа тээврийн хэлтсээс “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түрээслэх гэрээнд өөрчлөлт ороогүй бөгөөд гэрээний 1 дүгээр зүйлийн 1.9.3-т заасны дагуу “Бүс нутгийн логистикийн төв”-ийн хөрөнгөд хийгдэх ажлыг гуравдугаар хавсралтаар нэмж оруулсан. Уг хавсралтад “Монголын төмөр зам” ТӨХК, “УБТЗ” ХНН-ийн хийх 3 ажлыг оруулсан.

V. Компанийн төв оффист аж ахуйн материал, бичиг хэргийн материалын зардалд сар бүр 7.0 сая төгрөг зарцуулдаг байсан бөгөөд аж ахуйн материал, бичиг хэргийн материалын тайлан тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулснаар 09 дүгээр сараас эхлэн 4.0 сая төгрөг болгон зөвхөн шаардлагатай зүйлсийг худалдан авч зарцуулдаг болсон.

VI. Төрийн аудитын тухай хуулийн дагуу Үндэсний аудитын газраас компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 36 асуудлын хэрэгжилт 90 хувийн биелэлттэй дүгнэгдсэн ба үлдсэн 10 хувь болох 9 асуудал нь 30-80 хувийн биелэлттэй байгаад дүгнэлт хийж, эдгээр асуудлуудыг тайлант онд багтаан барагдуулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцлагыг тодорхой болгох талаар 2 зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Үүнд:

Хэрэгжилтийн байдал: Хяналтын албанаас тухайн асуудал хариуцсан газар, хэлтсийн дарга, ажилтнуудтай биечлэн уулзаж, хэрэгжилт дутуу байгаа асуудлыг тодорхой тайлбарлан танилцуулж, шуурхай арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй байгаа ч аудитын зүгээс холбогдох 3 хэлтсийн дарга, албан тушаалтнуудад удаа дараа сануулж, эдгээр ажлыг эрчимжүүлэх, хугацаа алдахаас сэргийлэн ажиллаж байна.

VII. Шилэн дансны www.shilendans.gov.mn вэбсайтад мэдээлэл байршуулахдаа хариуцлагатай хандах, мэдээллийн чанар, стандартад анхаарах тухай 2 зүйлийн зөвлөмжийг Захиргаа, удирдлагын газрын Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Худалдан авалтын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газрын Төлөвлөлтийн хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

VIII. Цогтцэций болон Төмөртэй өртөөний ажилчдын нийтийн хоолыг нийлүүлэх /катеринг/ үйлчилгээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах шалгаруулалтын тухай санал, дүгнэлтэд нотлох баримт үндэслэн, хууль эрх зүйн хүрээнд аудит хийж 2 асуудлаар 4 зүйлийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

IX. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Захиргаа, удирдлагын газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсүүдийг хамруулан 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 25-ний өдрийг дуусталх хугацааны ажиллагсдын цалин хөлсний тооцоолол, олголтын үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэж 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр холбогдох газруудад зөвлөмжийг хүргүүлсэн.

1.6.2. Тээврийн хяналт

Гүйцэтгэх захирлын баталсан Хяналтын албаны тээврийн хяналтын байцаагч нарын шугам замд ажиллах хуваарийн дагуу Тээврийн хяналтын байцаагч нар нь 14 хоног тутам ээлж солилцох байдлаар орон нутагт ажиллаж байгаа ба Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, зам, сумын техникийн байдал, нормт хэмжээснүүд, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэрэгжилт, ажилтны сахилга хариуцлагын байдалд “Хяналт шалгалтын журам”-ын дагуу үзлэг шалгалт хийж, илэрсэн үл тохирлуудыг засаж хэвийн болгох талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.

Төмөр замын тээврийн үйлчилгээний чанар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан хүрээнд хяналт тавьж, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд 2023 оны 07 сарын 05-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд хяналт шалгалтын ажлыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.

Цогтцэций зангилааны аж ахуйн нэгж хэсгүүд, Цогтцэций хэсэглэлийн зөрлөгүүд, Төмөртэй өртөө, түүний нэгж хэсгүүдэд галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, өртөө, зөрлөгүүдийн зам сум, холбоо дохиолол, хиймэл төхөөрөмж байгууламжуудын хэвийн ажиллагаа, нормт арчилгаа үйлчилгээний байдал, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж байнгын хяналт тавьж илэрсэн зөрчил

дутагдлуудыг тухай бүр арилгуулж хэвийн болгуулан холбогдох албан тушаалтан ажилтнуудад заавар зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан хяналт тавьж ажилласны дүнд галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой гологдол, сүйрэл, хөдөлмөр хамгааллын осол, зөрчилгүй ажиллаж байна.

Төмөртэй өртөө, Цогтцэций хэсэглэлийн хэмжээнд хяналт шалгалтаар гарсан дутагдал, үл тохирлуудыг арилгаж хэвийн болгох талаар 3 удаагийн зөвлөмж боловсруулж газар, хэлтсүүдэд хүргүүлсэн ба 2 зөвлөмжийн биелэлтийг хангуулж хариу авсан бол 1 зөвлөмжийн биелэлтийн хугацаа болоогүй байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар газар, хэлтсүүдэд хүргүүлсэн зөвлөмжийг төрлөөр нь ангилан авч үзвэл:

- Хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр 20
- Замын аж ахуйн чиглэлээр 30
- Хөдлөх бүрэлдэхүүний аж ахуйн чиглэлээр 68
- Дохиолол холбооны аж ахуйн чиглэлээр 36
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

1.6.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу компани байгуулагдсан цагаас хойш батлагдан гарч мөрдөгдөж буй бүхий л дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж гаргаж 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр холбогдох газруудад хүргүүлсэн.

Компанийн гадагшаа явж буй тайлан мэдээ, Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгавар, хууль тогтоомжийн биелэлт зэрэг бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

2021 оны Хөдөлмөрийн хуулийн /шинэчилсэн найруулга/, 2022 оны “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 6 дугаар тогтоол”-д тус тус заасны дагуу ажиллагсдын цалин, хөлс олгох үйл ажиллагаа нь үнэн зөв тооцоологдож байгаа эсэхийг хянаж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулах компанийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж байгаатай холбогдуулан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.2.3-т заасан “Хяналт-шинжилгээ, үнэлэлт дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах” гэснийг үндэслэл болгон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж ажиллах тухай зөвлөмжийг газар, хэлтсийн дарга нарт 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

1.6.4. Эрсдэлийн удирдлага

1. Компанийн бүтэц, зохион байгуулалтын нэгж өөрчлөгдсөнтэй холбогдуулан эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/126 тоот тушаалаар шинэчлэн томилсон бөгөөд 2023 оны 02 дугаар сард баталсан “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх” төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж эрсдэлийн хорооны гишүүдийн 2023 оны 11 сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж үүрэг чиглэл өгч ажилласан.

2. Авлигатай тэмцэх газар, “Онч шийдэл” ТББ-аас компанийн авлигын эрсдэлийн үнэлгээг хийж 11 эрсдэл бүхий зөвлөмжийг гаргасан бөгөөд уг зөвлөмжийн хэрэгжилт болон эрсдэлийг бууруулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангийн хамт ирүүлэх тухай албан бичгийг газар, хэлтсийн дарга нарт хүргүүлсэн.

3. Эрсдэлийг тодорхойлох аргачлал боловсруулж, эрсдэлийн журмын төслийг

боловсруулж компанийн эрсдэлийн үнэлгээний хороогоор хэлэлцүүлж санал авсан.

2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

2.1. Тээвэр зохион байгуулалт, тээвэрлэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл



2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын “Цогтцэций” өртөөг аюултай ачаанд нээлттэй өртөөгөөр зарласан.

Цогтцэций өртөө түүний харьяа зөрлөг, Төмөртэй өртөөний галт тэрэгний хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдалд тогтмол хяналт тавих, ачаа тээврийн үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, тээвэрлэж буй ачааны бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих, тээвэрлэлтийн гэрээний дагуу ачаа урсгалыг оновчтой болгох, тээвэрлэлтийн найдвартай байдал, аюултай ачааны ачилт буулгалт болон тээвэрлэлт нь ОУАХ-ийн техникийн нөхцөл шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавих, тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаардсан /урт болон хүнд/ ачаануудыг ачих буулгах, ГХБ-ийн журам болон түүнд тавигдах шаардлага, холбогдох стандарт, шаардлагын биелэлтийг хангуулах чиглэлээр ажиллаж байна. Мөн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эзэмшлийн ачааны 215 хагас, 10 битүү, 50 тавцант, 57 хоппер вагонуудын замын байдалд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3.5 сая.тн ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөнд тодотголд оруулж 2.5 сая.тн тээвэрлэхээр төлөвлөн 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 23/21 дугаар тогтоолоор батлуулсан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,843,760 тонн ачаа тээвэрлэж, 72 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2.1. Тээвэрлэсэн ачааны хэмжээ (2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)


Д/д	Чиглэл	Ачааны нэр	Төрөл	Төлөвлөгөө /ачааны хэмжээ/	Гүйцэтгэл		Биелэлт
					Вагон	Ачаа /тонн/	
1	Цогтцэций - Зүүнбаян	Сайжруулсан шахмал түлш /мидлинг/	Орон нутаг	305,311	6,523	422,672	138%
2	Цогтцэций - Зүүнбаян	Нүүрс	Экспорт	423,550	1,048	71,230	17%
3	Цогтцэций - Ханги	Нүүрс	Экспорт	1,163,877	11,555	783,487	67%
4	Цогтцэций - Зүүнбаян	Орон нутаг /мидлинг/	Орон нутаг	101,733	512	32,819	32%
5	Зүүнбаян- Цогтцэций	Түлш болон бусад	Импорт	135,693	13,812	126,038	93%
6	Зүүнбаян- Цогтцэций	Барилгын материал	Орон нутаг	113,292	3,163	170,249	150%

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

7	Төмөртэй-Хандгайт	Төмрийн хүдэр	Экспорт	303,476	3,454	237,265	78%
Нийт дүн				1,843,760			72%

5. ТӨМӨР ЗАМЫН ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

5.1. Баруун босоо чиглэлийн төмөр замын төсөл



Баруун босоо чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилд 25-30 сая тонн ачаа тээвэрлэх боломжтой. Төмөр зам дагасан томоохон суурьшлын төвүүд болон ажлын байрууд шинээр бий болж, уул уурхайн салбараас гадна хүнс, мал аж ахуйн салбар, арьс ширний үйлдвэрлэл, тэдгээрийн логистикт чухал нөлөө үзүүлнэ.

Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн 2023 онд хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/143 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлж батлуулсан бөгөөд баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд нийт 35 удаа тус тус цахимаар хүргүүлсэн.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 10 дугаар сарын 23 дугаар шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК-аас бэлтгэл ажлын төлөвлөгөө болон барилга угсралтын ажлын төлөвлөгөөнд санал авч, боловсруулалт хийж батлуулахаар Зам, тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 11 дүгээр сард хүргүүлсэн.

<p>Төслийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулахаар хүргүүлсэн бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ЗТХЯ-наас баталгаажуулсан.</p>	<p>“Монголын төмөр зам” ТӨХК болон “Эссенз саплайз” ХХК нар 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г байгуулсан.</p>	<p>“Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК байгуулагдаж, Улсын бүртгэлд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр бүртгүүлж, гэрчилгээ авч, 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр тамга, тэмдгийг авсан.</p>	<p>2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг томилсон.</p>
---	--	--	---


Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/261 дүгээр тушаалаар Засгийн газрын шийдвэрээр концесс олгосон этгээдтэй хэлэлцээ хийж, шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан

бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн анхдугаар хуралдаан хуралдаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/261 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгтэй хэлцэлд орох зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд олгосноор 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс концессын гэрээний хэлцэл эхэлсэн. Хэлцлийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК-тай концессын гэрээний төслийг нэгтгэн, Гүйцэтгэх захирлын 01/1781 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

“Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК нь төслийн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 006 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ЭЗХОГ-ын даргын 562 дугаар албан бичгээр Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийн урьдчилсан ТЭЗҮ-д санал, дүгнэлт гаргах 13 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдож, дүгнэлт гарган ажиллаж байна.

5.2. Зүүн босоо чиглэлийн төмөр замын төсөл



Зүүн босоо чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилд 20-25 сая тонн ачаа тээвэрлэх боломжтой. Бичигт-Эрзэнцав чиглэлийн төмөр замын коридор нь Орос, Хятадыг холбосон төмөр замаас даруй 500 км-р богино бөгөөд тонн тутмаас 12 ам.доллар хэмнэх боломжтой юм. Энэ зам нь Европ болон Хятадыг холбосон ачаа тээвэрт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/143 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлж батлуулсан бөгөөд зүүн босоо чиглэлийн төмөр замын төслийн нарийвчилсан төлөвлөгөөний хугацааг төслийн ажлын явцтай уялдуулан шинэчлэн боловсруулсан. Шинэчилсэн боловсруулсан ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд санал авахаар “Ийст коридор рэйлрүүд” ХХК-д албан бичгээр хандсан.

<p>✓</p> <p>Төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулан “Ийст коридор рэйлрүүд” ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.</p>	<p>✓</p> <p>“Монголын төмөр зам” ТӨХК болон “Ийст коридор рэйлрүүд” ХХК нар 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г байгуулсан.</p>	<p>✓</p> <p>“Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК байгуулагдаж, Улсын бүртгэлд 2023.07.05-ны өдөр бүртгүүлж, Улсын бүртгэлийн гэрчилгээг авсан.</p>	<p>✓</p> <p>2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг томилсон.</p>
---	--	---	--

Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426 км төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлыг БНХАУ-ын China Railway Design Corporation Ltd (CRDC)-тэй гэрээ байгуулан 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зам, тээврийн хөгжлийн яам, “Монголын төмөр зам” ТӨХК, “Ийст корридор рэйлрөүд” ХХК-тай хамтран Тусгай зориулалтын компанитай Концессын гэрээ хийх, шууд гэрээ байгуулах ажлын хэсгийн хурлыг 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулан ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн гэрээнд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

5.3. Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнансан төмөр зам



Шивээхүрэн боомтын нарийн царигийн төмөр замаар 2024-2029 онуудад 10 сая тонн ачаа тээвэрлэх бөгөөд 2029 оноос хойш Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн өргөн царигийн төмөр замын ТЭЗҮ-ээр, Бичигт боомтын нарийн царигийн төмөр замаар 2024-2030 онуудад жилд 8 сая тонн ачаа тээвэрлэх бөгөөд 2030-2045 онуудад тээвэрлэх ачааны хэмжээ Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн өргөн царигийн төмөр замын ТЭЗҮ-ээр тус тус тодорхойлогдоно.

Хилийн боомтуудын төмөр замын төслийн 2023 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/143 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлж батлуулсан бөгөөд биелэлтийг 7 хоног тутам Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдад тайлагнан ажилласан.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 23/04 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 51 хувь, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн 49 хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан.	Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнансан төмөр замуудын ТЭЗҮ, зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулсан.	Батлагдсан ажлын даалгаврын дагуу Шивээхүрэн-Сэхэ хил дамнансан төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр ЗТХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.	Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, барилгын ажил эхлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын тогтоол гаргасан.

Төслийн талбайд инженер геодези, инженер-геологи, геотехник, гидрологи, археологийн судалгааны ажлуудыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан.

БНХАУ-ын “Төмөр замын зураг төслийн корпорац”-ийн /CRDC/ боловсруулсан Шивээхүрэн-Сэхэ боомтын төмөр замын нарийвчилсан зураг төслийг хянаж, ЗТХ-ийн төвөөр магадлуулах ажлыг зохион байгуулсан.

Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын талаар хятадын талтай хийх яриа хэлэлцээрийн удирдамжийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсан бөгөөд Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын асуудлаар 2023 оны 05 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд “Хятадын төмөр замууд” корпорацитай уулзалт зохион байгуулж протокол үйлдсэн.

Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын барилгын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 27-ний өдөр эхлүүлсэн. Барилгын ажлын нийт гүйцэтгэл – 57 хувь

Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замыг барих ажилд техник технологийн хяналтыг хэрэгжүүлэх тухай 250 сая төгрөгийн ажлын хөлс бүхий гэрээг “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай 2023 оны 07 дугаар сард байгуулж гэрээнд заагдсан ажлын даалгаврын дагуу хяналтыг хэрэгжүүлж байна.

Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын өртөөнд ГЕГ болон ХХЕГ-ийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай нэмэлт арга хэмжээнүүдийн саналыг судалж, шийдвэрлэх арга хэмжээг хөрөнгө оруулагч талтай хэлэлцэж шийдвэрлэсэн.

Хүснэгт 5.1. Ажлын гүйцэтгэл

Д/д	Ажлын нэр	Гүйцэтгэл
1.	Газар шорооны ажил	95%
2.	Хоолойн ажил	96%
3.	Өртөө, зөрлөгийн барилгын угсралтын ажил	28%
4.	Эрчим хүчний барилга угсралтын ажил	54%
5.	Дээд бүтцийн үе угсрах ажил	15%
Нийт ажлын гүйцэтгэл		57.6%

Бичигт-Зүүнхатавч боомтын төмөр замын төслийн бүтээн байгуулалт үйл ажиллагааны шатанд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/149 дугаар тушаалаар ХХЕГ, ГЕГ болон “Ийст корридор рэйлрөүд” ХХК-ийн төлөөллийг оролцуулан ажлын хэсгийг байгуулж, ХХЕГ, ГЕГ-аас нэмэлт арга хэмжээний саналуудыг авч ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шатанд тусгаж оруулсан.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан ажлын даалгаврын дагуу Бичигт-Зүүнхатавч хилийн боомтын төмөр замын ТЭЗҮ боловсруулж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Бичигт боомтын хил дамнасан нарийн царигийн төмөр замын барилгын ажлыг 2024 онд эхлүүлнэ.

5.4. “Тяньжин тээвэр логистикийн төв” төсөл



Тяньжины тээвэр логистикийн төвийг байгуулснаар Далайд гарцгүй Монгол Улсыг Ази, Европ болон бусад тивтэй холбосон тээврийн оновчтой сүлжээг бий болгож, тээвэр логистикийн үйл ажиллагааг зохицуулах, Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн болон малын гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэнэ.

“Монгол-Тяньжины Дунзян тээвэр логистикийн төв” төслийн ажлыг яаралтай эхлүүлэхийн тулд “Монголиан порт групп” ХХК -ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, тус төсөлд хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Зам, тээврийн хөгжлийн сайдын 03 дугаар шуурхай хуралдаанаас “Монголын төмөр зам” ТӨХК-д үүрэг болгосон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Гүйцэтгэх захирлын А/30 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан.

“Монголиан порт групп” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, “Монголиа уул уурхай хөрөнгийн менежмент” ХХК-д “Монголиан порт групп” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай албан бичгийг удаа дараа хүргүүлсэн боловч хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулаагүй. Иймд 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-аас 03/949 дугаар албан бичгээр “Өвөр монголын уурхай үйлдвэрийн эд хөрөнгө хамааралтын” ХХК болон түүний 100 хувийн хөрөнгө оруулалттай Монгол Улсад бүртгэлтэй “Монголиа уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК-д гэрээ цуцлах мэдэгдлийг өгсөн.

“Монголиан порт групп” ХХК-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигч БНХАУ-ын “Өвөр Монголын уурхайн үйлдвэрийн эд хөрөнгийн хамааралтын” ХХК нь өөрийн эзэмшлийн хувьцааг “Чингисхаан групп” ХХК-д худалдахаар харилцан тохиролцож, гэрээ хэлцэл хийгдэж байгаа тухайгаа “Монголын төмөр зам” ТӨХК-нд 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хийсэн уулзалтаараа мэдэгдсэн. Үүссэн нөхцөл байдлын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-аас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Зам, тээврийн хөгжлийн яаманд чиглэл хүссэн 01/1102 дугаар албан бичгийг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн.

2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдаас “Төрийн өмчийн оролцоотой “Монголиан порт групп” ХХК-ийн хувьцааг өөр компанид худалдах, шилжүүлэх ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчиж байгаа тул уг асуудлыг таслан зогсоож, ХАГ18-115110/08 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг цуцлах” чиглэл ирүүлсний дагуу “Монголиан порт групп” ХХК-ийн ХАГ18-115110/08 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг цуцлахтай холбоотойгоор уг төсөлд хөрөнгө оруулагчийг дахин сонгон шалгаруулах шаардлага үүссэн. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 152 дугаар тогтоолоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайдад даалгасан байдаг тул “Монголын төмөр зам” ТӨХК-аас Шадар сайдад 01/1348 дугаартай чиглэл хүссэн албан бичгийг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлж энэ тухайгаа Зам, тээврийн хөгжлийн сайдад 01/1347 дугаар албан бичгээр мөн өдөр мэдэгдсэн.

“Монголиан порт групп” ХХК-ийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор ээлжит бус Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилсон. Мөн 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр “Монголиан порт групп” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулж ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг тус тус томилсон.

2023 оны 10 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх удирдлага БНХАУ-ын Хөх хотод “Монголиан порт групп” ХХК-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч тал болох “Монголиа уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК-ийн толгой компанийн удирдлагуудтай уулзаж хэлэлцээр хийсэн. Хэлэлцээрээр хөрөнгө оруулагч талаас төсөлд зориулан оруулсан нийт хөрөнгө оруулалтад тохирсон хувийг үргэлжлүүлэн эзэмшүүлэх эсвэл 100 хувь буцаан олгож гэрээг дуусгавар

болгох хэлбэрээр эрх ашгийг нь хөндөхгүй байх нөхцөлд хөрөнгө оруулагч уг саналыг хүлээн авч, хамтран ажиллахад татгалзах зүйлгүй болохыг илэрхийлсэн тул тус саналыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Тус асуудалтай холбоотойгоор 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр чиглэл хүссэн 01/1840 дугаар албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн сайд болон ТӨБЗГ-ын даргад тус тус хүргүүлсэн.

2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ТӨБЗГ-аас А-1/2242 дугаартай албан бичгээр энэ төслийг цаашид эрсдэл багатай, хугацаа алдахгүй, үр ашигтай хэрэгжүүлэхээр тооцож, хамгийн эрсдэлгүй ашигтай хувилбарыг сонгон ажиллах нь зүйтэй, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдаас “Хөрөнгө оруулагч гэрээгээр хүлээсэн үүргээ 2018 оноос хойш зохих ёсоор биелүүлээгүй тул “Монголиан порт групп” ХХК-ийн ХАГ18-11511008 дугаартай хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг цуцалж, Монголын талд учруулсан хохирол, торгууль, алдангийг тооцож авах нь зүйтэй” гэсэн чиглэлийг тус тус ирүүлсэн. Иймд Зам, тээврийн хөгжлийн сайдаас ирүүлсэн чиглэлийн дагуу “Монголиан порт групп” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, ХАГ18-11511008 дугаартай хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг цуцлах асуудлыг хэлэлцэх удирдамжийг хүргүүлэхээр ажиллаж байна.

5.5. Жинжоу боомт

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн төлөөлөгчид 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр БНХАУ-ын “Жиньжоу боомт” ХХК-ийн дэд ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзалт хийж тус боомтод “Монгол-Хятад-Оросын логистикийн жишиг парк”-ийг байгуулж хамтран ажиллахаар тохиролцсон.

“Жиньжоу боомт” ХХК-аас ирүүлсэн санамж бичгийн төслийг боловсруулж 09, 10 дугаар саруудад “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Зам, тээврийн хөгжлийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга нарт төслийг танилцуулгын хамт хүргүүлсэн бөгөөд ирүүлсэн саналыг санамж бичигт тус тус тусган боловсруулж 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр санамж бичгийг байгуулсан.

5.6. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 300 дугаар тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 300 дугаар тогтоолын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/131 дүгээр тушаалаар Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төсөлд хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох бэлтгэл ажлыг хангах үрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төсөлд хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох “Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг”-ийн төслийг боловсруулсан бөгөөд “Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг”-ийн төсөлд санал, чиглэл авахаар 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1531 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлсэн.

5.7. Төлөвлөлт

Гүйцэтгэх Захирлын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/105 дугаар тушаалаар байгуулагдсан “Компанийн дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж “Дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан.

Компанийн Гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу компанийн 2023 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орлогын төлөвлөгөөг бууруулж, зардлын төсвийг хассан байдлаар тодотгол хийж, мөн оны бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 23/21 дугаар тогтоолоор дэмжигдэн ТӨБЗГ-ын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 481 дугаар тогтоолоор батлуулж, гүйцэтгэлийг ханган ажилласан.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 23/30 дугаар тогтоолоор тус тус дэмжүүлсэн. Дэмжигдсэн төлөвлөгөөг ТӨБЗГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө боловсруулж 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

5.8. Статистик, мэдээлэл технологи

Зам, тээврийн хөгжлийн яамны “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-ыг ашиглаж, компанийн төмөр замын ачаа тээврийн үйл ажиллагаатай холбоотой болон бусад статистик тоон мэдээллийг Төв байгууллагад цаг тухай бүрд тайлагнах, мэдээллийг “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ” /www.platform.mrtd.gov.mn/-д нэгтгэн байршуулж байна. Үүнд “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын:

- “Маягт№1-Ачилт буулгалтын хоногийн мэдээ”,
- “Маягт№2в-Суурь бүтэц хоорондын галт тэрэг, вагон солилцооны хоногийн мэдээ”
- “Маягт№3-Галт тэрэгний зурмагийн тасалдлын хоногийн мэдээ”,
- “Маягт№6-Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ”,
- “Маягт№7-Ачилтын мэдээ /өссөн дүнгээр/”
- “Маягт№9б-Ачаа тээвэрлэлтийн мэдээ”
- “Маягт№Т-9-Төмөр замын тээврийн сарын тээвэрлэлтийн мэдээ”-ний дагуу өдөр тутам болон хийгдсэн ажил тухай бүр өссөн дүнгээр нэгтгэн оруулж, статистик үзүүлэлтийн чарт үүсгэн байршуулсан байна.

Тээврийн нэгдсэн платформуос зарим тоон мэдээлэл, үзүүлэлт олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар нэгтгэгдэн <https://digital.mrtd.gov.mn/> порталд тавигдаж байна. Мөн “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д оруулаагүй байсан 2023 оны 8 дугаар сараас өмнөх саруудын болон 2022 оны мэдээлэл датаг нөхөн оруулж, мэдээллийн сан, чартуудыг үүсгэн байршуулсан.

Компанийн үйл ажиллагаатай холбогдох бусад маягтуудын үндсэн бүтцийг зурах, бусад төмөр замын байгууллагуудтай уялдуулах, нэгдсэн ижил бүтцэд оруулах ажлууд хийгдэж байна.

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 77/109 тоот тушаалаар байгуулагдсан “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-ын хөгжүүлэлтийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 07, 08, 25-ны өдрүүдэд ЗТХЯ-нд ажиллаж “Нэгдсэн платформ”-ын мэдээллийн зарим зөрүүтэй ойлголтууд байсныг бусад төмөр замын байгууллагуудтай нэгдсэн ойлголтод хүрч, салбарын хэмжээнд гаргах боломжтой статистикийн болон бусад мэдээллийн жагсаалтыг гаргаж, цэс, бүтэц үүсгэх, нэгтгэл хийх, хийгдэх үйлдлүүдийг илүү ойлгомжтой хялбар болгох, зарим маягтыг томъёолж оруулах, оруулсан дата мэдээллүүдээс тайлан гаргаж авах боломжтой болгох зэрэг ажлуудыг хийсэн. Ажлын хэсгийн ажил цаашид “Нэгдсэн платформ”-ыг бүрэн ашиглалтад оруулж, ЗТХЯ хүлээн авах хүртэл үргэлжилнэ.

“Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг шинэчлэн батлах гэж байгаатай холбоотойгоор маягтуудыг шинэчлэх, боловсронгуй болгох, давхардсан мэдээллүүдийг нэгтгэх, шаардлагатай мэдээллүүдийг нэмэх талаар санал солилцон, төслийн ажилд оролцож байна.

193 хэрэглэгчтэй цахим шуудан болон 1 домэйн, 1 хостингийн үйлчилгээг “Мэйжикнэт” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ашиглаж байна. Цаашид хэрэглэгчийн тоог нэмэх шаардлагатай тул 2024 оны төсвийн төсөлд тусган ажиллаж байна.

Удирдлагын багт ашиглах, төслийн удирдлагын “Trello” системийг судалж, гарын авлагыг боловсруулсан.

Байгууллагын “Docs” программд шинээр ажилд орсон 30 гаруй ажилтны бүртгэлийг үүсгэн холбогдох тохиргоог хийж нэвтрэх нэр болон нууц үгийг үүсгэн өгч, ажлаас чөлөөлөгдсөн ажилтны хэрэглэгчийн эрхийг идэвхигүй болгож хязгаарлалтыг хийсэн.

Нийт 50 гаруй компьютерыг форматлаж холбогдох программ хангамжуудыг суулган өгч хэвийн ажиллагаанд оруулж, төв оффисын принтерүүдийн сүлжээний тохиргоонуудыг шинээр хийн тохируулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн байгууллагын дотоод файл дамжуулах шэйр серверийн тохиргоог хийн бүх /200 гаруй/ албан хаагчдын компьютер дээр суулган тохируулсан.

“Зүүнбаян – Тавантолгой” чиглэлийн төмөр замын бүх өртөө зөрлөгүүдэд ажиллаж интернэт сүлжээ, хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хяналт тавьж бүрэн бус, гэмтэлтэй тоног төхөөрөмжийн судалгаа тоо ширхгийг гаргасан.

“Зүүнбаян – Тавантолгой” чиглэлийн төмөр зам технологийн бус хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд үзлэг хийж шаардлагатай сэлбэг эд анги болон гэмтэлтэй тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган нэн шаардлагатай сэлбэг хэрэгслийн тооцоог хийж төсөвт тусгасан.

Засварын депо, зүтгүүрийн депо, вагон пүү, дэд станцын интернэтэд холбогдоогүй байснаас зүтгүүрийн депог интернэт холболтыг газар дээр нь шийдвэрлэж интернэтэд холболт хийсэн. Засварын депо, вагон пүүний техникийн нөхцөлийг гаргаж шаардлагатай тоног төхөөрөмжийг захиалгад оруулж холболтын ажил хийгдэж байна.

6. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Компанийн үндсэн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй төмөр замын төсөл, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд нийцүүлэн контентын бүх төрлөөр бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчидтэй хамтран компанийн үйл ажиллагаа, цаг үеийн онцлох 68 мэдээ мэдээллийг бэлтгэж, нийт 21 хэвлэл мэдээллийн байгууллагаар нийтлүүлсэн.



Хэвлэлийн бага хурал :

2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Төмөр замын бүтээн байгуулалт, цаг үеийн сэдэв” хэвлэлийн хурлыг зохион байгуулж, бүтээн байгуулалтын мэдээ мэдээллийг сурвалжлан олон нийтэд түгээсэн.

6.1. Компанийн цахим хуудас хөтлөлт

Компанийн үйл ажиллагааны танилцуулга, салбар нэгжүүд, хэрэгжүүлж буй төмөр замын төслүүдийн мэдээллийг Монгол, Англи хэл дээр тогтмол шинэчлэн нийтэлсэн бөгөөд дагагчийн тоог 17.5К-20.8К болгон өсгөсөн.

Хүснэгт 6.1. Мэдээ мэдээллийн тоо

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийн тоо
1.	Вэб сайт: www.mtz.mn	
1.1.	Цаг үе үйл явдлын мэдээ	85
1.2.	Мэдээ /Англи хэл/	34
2.	Пэйж хуудас: “Монголын Төмөр Зам” ТӨХК	
2.1.	Сошиал медиа дээр нийтлэгдсэн мэдээлэл	Цаг үеийн мэдээ /гэрэл зурагтай/ - 110
		Постер – 24
		Видео мэдээлэл - 23
		Reel - 6

2.2.	Видео	<ol style="list-style-type: none"> 1. Шивээхүрэн-Сэхэ боомтын төмөр замын бүтээн байгуулалт 2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үзүүлэлт, шатахуун тээвэрлэлт, экспортын тээвэрлэлт 3. Галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагаар зохион байгуулж байна 4. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 84 жилийн ойн мэндчилгээ 5. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд хориг хашаа барьж байгуулах тухай 6. МТЗ ТӨХК-ийн 100 хоногийн ажлын тайлан 7. Инженерүүдээ алдаршуулах /Тээвэр зохион байгуулалтын инженер/ 8. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үйл ажиллагааны танилцуулга /Англи хадмал/ 9. “Railway Mongolia 2023” үйл ажиллагаанд зориулсан Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
------	-------	---

6.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт

2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан тус хуулийн 8 дугаар бүлэгт заасан “Төрийн байгууллагад хамаарах зайлшгүй мэдээлэх үүрэгтэй 96 зүйл заалтын мэдээллийг холбогдох газар, нэгжээс хүлээн авч нэгтгэн тогтмол шинэчлэн нийтэлж ажилласан. Мөн компанийн үйл ажиллагааны танилцуулга, салбар нэгжүүд, хэрэгжүүлж буй төмөр замын төслүүдийн мэдээллийг Монгол, Англи хэл дээр тогтмол шинэчлэн нийтэлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны ХШҮДАГ-т 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, 09 дүгээр сарын 15-ны өдөр, 12 дугаар сарын 08-ны, ТӨБЗГ-т 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр тус тус хүргүүлсэн.

Мөн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн www.mtz.mn цахим хуудасны 7 бүлэг 52 төрлийн мэдээллийг тогтмол шинэчлэн нийтэлж байна.

6.3. Олон нийтийн үйл ажиллагаа

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар шатахуун тээвэрлэх тухай санамж бичиг зурах ёслолын үйл ажиллагаа. (2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр)
- Зам, тээврийн салбарын боловсролын үзэсгэлэн, Scholarship Road арга хэмжээ. (2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр)
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Монголиан транс лайн” ХХК-ийн хооронд суурь бүтцийг харилцан ашиглуулах хамтын ажиллагааны гэрээ байгуулах ёслолын ажиллагаа. (2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр)
- “Шивээхүрэн-Сэхэ” боомт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагаа. (2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр)
- Зам, тээврийн салбарын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт. (2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр)

- Төмөр замын тээвэр үүсэж хөгжсөний 84 жилийн ой, Төмөр замчдын мэргэжлийн баярын өдөрлөг. (2023.08.04-ний өдөр)
- “Бүсийн тээвэр, логистикийн холболтыг бэхжүүлэх нь” сэдэвт “Тээврийн долоо хоног 2023” Олон улсын форум 2023 оны 11 дүгээр сарын 6-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, тус арга хэмжээний 2 дах өдрийн “Railway Mongolia-2023” чуулга уулзалтад БНСУ-ын “Үндэсний төмөр зам” компани, “Yuucksan Power” компани болон ИБУИНВУ-ын суурь бүтэц үйлдвэрлэлийн “Пандрол” компанийн төлөөлөгчдийг панелистаар урьж оролцуулсан. Чуулга уулзалтын үеэр Гүйцэтгэх захирал Монгол Улсын төмөр замын салбарт тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцож, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөр, тэдгээрийн ач холбогдол, тулгамдаж буй асуудлаар санал бодлоо хуваалцав. Түүнчлэн арга хэмжээний үеэр үзэсгэлэн гаргаж, байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа томоохон төслүүдийн талаар танилцуулсан.
- Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохирох хэлэлцүүлэг. (2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр)

6.4. Гадаад хамтын ажиллагаа

Хөрш орнууд болон гуравдагч орнуудын төмөр замын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан туршлага солилцох, компанийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах хүрээнд шаардагдах техник, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх, “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Боомтын сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх баруун, зүүн, хөндлөн тэнхлэгийн төмөр замын болон тээвэр, логистикийн төслүүдийн явцыг эрчимжүүлэх зорилгоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлагууд гадаадын хөрөнгө оруулагч байгууллагуудын төлөөллүүдийг тухай бүр хүлээн авч, холбогдох уулзалт, арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд:


- БНХАУ-ын “Хятадын төмөр замууд” корпорац
- ОХУ-ын “Оросын төмөр замууд” НХН
- АНУ-ын Холбооны төмөр замын захиргаа
- БНСУ-ын Төмөр замын корпорац, Үндэсний төмөр зам компани
- БНХАУ-ын Тяньжин, Жинжөү боомтын захиргаа
- Төмөр замын техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн CRRC, Wabtec, Pandrol зэрэг үйлдвэрлэгч компаниуд
- Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөгчид



Зураг 6.1. БНХАУ-ын Хятадын төмөр замын зураг төслийн группийн төлөөлөгчид (2023.02.14)



Зураг 6.2. АНУ-ын Холбооны төмөр замын төлөөлөгчид (2023.09.19)



Зураг 6.3. ОХУ-ын Оросын төмөр замууд НХН-ийн төлөөлөгчид (2023.10.24)



Зураг 6.4. БНХАУ-ын Тяньжин порт группийн төлөөлөгчид (2023.11.20)

6.5. Гадаад айлчлал, албан томлолт

Компанийн шинээр хэрэгжүүлэх төмөр замын төслүүдийн асуудлыг хэлэлцэх, гадаадын төмөр замын байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож өргөжүүлэх, төмөр замын техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах хэрэгцээ шаардлагын хүрээнд тайлант хугацаанд нийт 25 удаагийн албан томилолтыг зохион байгуулсан. Үүнд:



БНХАУ-ын Эрээн, Хөх хот, Бээжин, Тяньжин Далянь, Чанжоу, Чинхуандао, Ляонин зэрэг хотуудад нийт 21 удаагийн томилолтыг зохион байгуулан ажилласан.

Эрээн хотод компанийн эзэмшлийн СКD4b зүтгүүрийг засварт хүлээлгэж өгөх, явцын хяналт тавих, хүлээж авах зорилгоор 6 удаа, Бээжинд хотод Монгол-Хятадын хилийн боомтын хил дамнасан төмөр замын төлөвлөлт, техникийн нөхцөлийг тохирох, хилийн хэлэлцээрийг шинэчлэх, хил холболтын асуудлаар хэлэлцээ хийх зорилгоор 7 удаа, Хөх хотод экспод оролцох, хил холболтын асуудлыг хэлэлцэх, Тяньжины Дунзян тээвэр ложистикийн төвийн асуудлыг хэлэлцэх зорилгоор 3 удаа, Ляонин мужийн Шэньян, Жинжөү хотуудад зүүн коридорын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэх зорилгоор 2 удаа, мөн Тяньжин хотод Тяньжины Дунзян тээвэр ложистикийн төв төслийн явцыг эрчимжүүлэх зорилгоор 1 удаа, Чинхуандао хотод СКD4b зүтгүүрийн явцын хяналт хийх зорилгоор 1 удаа, Нанку хотод хайрцган холхивч суурилуулах, засвар үйлчилгээ, сэргээн засварлах онолын сургалтад хамрагдах зорилгоор 1 удаа тус тус ажилласан.



ОХУ-ын Санкт-Петербург, Эрхүү хотуудад нийт 2 удаагийн томилолтыг зохион байгуулан ажилласан байна.

Санкт-Петербург хотод зураг төслийн программ хангамжийн мэргэшүүлэх сургалтад хамрагдах зорилгоор 1 удаа, Эрхүү хотод Монгол-Хятад-Оросын гурван улсын төмөр замын төлөөлөгчдийн ээлжит зөвлөгөөнд оролцож, баруун, зүүн босоо төмөр замын төлөвлөлт, бүтээн байгуулалтыг танилцуулах, Арцсуурь-Цагаантолгой боомтын төмөр замын хил холболтын асуудлыг хэлэлцэх зорилгоор 1 удаа тус тус ажилласан.



БНСУ-ын Сөүл хотод нийт 2 удаагийн томилолтыг зохион байгуулан ажилласан байна.

БНСУ-ын КОТИ консорциумаас “Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь” төслийн хүрээнд зохион байгуулсан “Төмөр зам, ложистик, эрдэс баялгийн салбарын чадавхыг бэхжүүлэх” сэдэвт зөвлөгөөнд хамрагдах, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн “Барилга барих, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах” төслийн хүрээнд сургалтад хамрагдах зорилгоор 2 удаа ажилласан.



Зураг 6.5. Монгол-Хятадын Экспо, Монгол-Хятадын төрийн өмчийн аж ахуйн нэгжийн шинэчлэл, хөгжлийн хэлэлцүүлэг уулзалтын үеэр. (БНХАУ, Хөх хот 2023 оны 09 дүгээр сар)



Зураг 6.6. ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын хилийн төмөр замын төлөөлөгчдийн зөвлөгөөн (ОХУ, Эрхүү хот 2023 оны 10 дугаар сар)



Зураг 6.7. Хятад-Монгол-Оросын орон нутгийн эдийн засаг, худалдааны чуулга уулзалт (БНХАУ, Жинжөв 2023 оны 10 дугаар сар)

6.6. Олон улсын арга хэмжээ

Монгол Улс, БНХАУ-ын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөн

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан Монгол Улс, БНХАУ-ын хилийн төмөр замын комиссын ээлжит зөвлөгөөнд оролцож, Хятадын талд Шивээхүрэн-Сэхэ боомтын хил дамнансан төмөр замын төслийн талаар танилцуулав.

Зүүн Азийн төмөр замын холболтыг бэхжүүлэх тухай олон улсын семинар

Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжиж байгаа “Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги, Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэгийн үүсгэн байгуулалттай уялдах нь” төслийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгосын “КОТИ” корпорациумтай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Зүүн Азийн төмөр замын холболтыг бэхжүүлэх тухай олон улсын семинар”-ыг зохион байгуулсан.



Зураг 6.8. Монгол Улс, БНХАУ-ын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөн (2023.02.06)



Зураг 6.9. Зүүн Азийн төмөр замын холболтыг бэхжүүлэх тухай олон улсын семинар (2023.04.05)

6.7. Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээр



Вагон үйлдвэр, засвар үйлчилгээний чиглэлээр инженер, техникийн ажилчдыг чадавхжуулах, ачааны вагоныг хөнгөлөлттэй үнээр зах зээлд нийлүүлэх боломжийг харилцах судлах тухай “МТЗ” ТӨХК болон БНХАУ-ын “Си Ар Ар Си Цицикар вагон үйлдвэр” ХХК хоорондын Хамтын ажиллагааны санамж бичиг (2023.06.10);



Стратегийн түншлэл, харилцан ашигтай хамтын ажиллагааны тухай “Монголын төмөр зам” ТӨХК болон ОХУ-ын “Группа Компаний 1520” ХХК хоорондын санамж бичиг (2023.11.07);



“Монгол-Хятад-Оросын ложистикийн төв” төслийн бүтээн байгуулалтыг урагшлуулах, Монгол Улсын зүүн босоо тэнхлэгийн төмөр замын бүтээн байгуулалтыг дэмжих тухай “Монголын төмөр зам” ТӨХК болон БНХАУ-ын “Жинжөү боомт” ХХК хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг.